



# 9-р сарын тайлан

Хүүхэд бүхэн инээнэ  
Ид шидийг бүтээнэ ...



Ид шидийн орон ХХХТ-н **2021.09.31**  
ТООН ҮЗҮҮЛЭЛТ  
ТҮР ХАМГААЛАХ БАЙРАНД



НИЙТ ҮЙЛЧЛҮҮЛЭГЧ

14

ХҮЛЭЭН АВСАН  
ҮЙЛЧЛҮҮЛЭГЧИД

+6

Хүйс



Эмэгтэй

11



Эрэгтэй

3

Нас



2-5 нас

2



6-10 нас

2



11-13 нас

7

Тайлбар:

“Ид шидийн орон” ХХХТ-н түр хамгаалах байранд 2021 оны 9 сард шинээр 6 үйлчлүүлэгч хүлээн авч, 1 үйлчлүүлэгчийг ар гэрт нь эргэн нэгтгэж 2 үйлчлүүлэгчийг харьяа хороо дүүрэгт нь хүлээлгэн өгсөн байна. Өнөөдрийн байдлаар 14 үйлчлүүлэгч хамгаалах байрны цогц үйлчилгээг авч байна. Үүний 11 эмэгтэй, 3 эрэгтэй. 2-5 насны 2, 6-10 насны 2, 11-14 насны 7, 14-18 насны 3 үйлчлүүлэгч үйлчилгээ авч байна.

# НИЙГЭМШИХҮЙН ХӨГЖЛИЙГ ДЭМЖИХ

Энэ сарын нийгэмшихүйн хөгжлийг дэмжих үйл ажиллагааны хүрээнд түр хамгаалах байрны үйлчилгээнд хамрагдаж байгаа үйлчлүүлэгчдийг үндэсний соёл амралтын хүрээлэнд агаарт гаргасан.



## Онцлох мэдээлэл

Хамгаалах байрны үйлчилгээнд хамрагдаж байгаа 3 үйлчлүүлэгчийг гэр бүлийн гишүүдтэй уулзуулах уулзалтыг харьяа хороо дүүргийн мэргэжилтнүүдтэй хамтран зохион байгуулсан.

# Ид Шидийн Орны бяцхан гүнж



Түр хамгаалах байранд маань шинээр бяцхан гүнж ирсээн. Ердөө 3 настай байж үнэхээр мундаг ярьдаг нээлттэй хүүхэд. Дөнгөж ирээд ирэх үеийн үзлэгтээ хамрагдахаар өрөөнд орохдоо сайн уу намайг ..... гэсээр орж ирээд сандал дээр суугаад таньд чихэр байгаа юмуу гэж асууж билээ.



зүүн гараар зүрх  
гаргасан байдал

Үзлэг хийгдэж дуусаад хувцасаа өмсөж  
байгаа болон ирэх үеийн зураг даруулалт.



ДАХИАД

# Хоолондоо

Хүүхдүүд 12:40-с хоолондоо орсны дараа 13:00 цагаас багш нар хоолондоо ордог, гэтэл дөнгөж хоолоо идээд гарсан хүүхэд маань багш нарын цайны цагаар нэг багш нь шөл гаргах гэж чанасан яс урдаа тавиад сууж байтал орж ирээд надаа гэсээр нэгийн бариад их л амтархан мөлжиж гарлаа шүү



9 САРЫН 1 БОЛЛОО

## Ерөөсөө бидний баярдаа

9 сарын 1 болж хичээл сургууль орсонтой холбоотой хамгийн бяцхан үйлчлүүлэгч маань цэцэрлэгт явахаар болов. Албандаа мордохын тулд шээс болон шимэгч хорхойн шинжилгээ шаардлагатай учир бусдын жишгээр эртлэн босоод очерлож шинжилгээгээ өгөв.



Албандаа явж эхэлсэн хүн маань зарим өглөө ууртай, зарим өглөө их л баяртайгаар **"baby shark"** аялсаар явж өгнөө. Ангидаа ороод хамгийн түрүүн хийдэг зүйл бол мэдээж гадуур хувцасаа солих, харин манай хүн сайхан ааштай үедээ хэнээр ч заалгахгүй өөрөө цэгцэлчихнэ.

## НАМРЫН НАЛГАР ӨДРҮҮДИЙГ

# Хөгжилтэй өнгөрөөлөө

Хичээл орж намрын налгар өдрүүд үргэлжилж байгаатай холбоотой хүүхдүүдээ аваад цэцэрлэгт хүрээлэнд нэг өдрийг өнгөрөөлөө. Бидний гол зорилго бол дугуй унах байсан юм. Тиймээс том багагүй бүгд л дугуй уналаа харин дугуй унагчдаас хамгийн бяцхан залуу маань хамгийн тухтай хамгийн догь нь байлаа.



**урдаасаа бол их л жаргалтай  
инээд алдаад явж байгаа  
царай байгаа шүү**

Мэдээж тоголоод өлсөөд цангасаан. Цангаагаа түрхэн зуур зайрмагаар дараад зарим багш нар идэх юманд явах хооронд бяцхан 2 маань тортой юмандаа эзэн болж буй байдал.



**уул нь бол бүгд хувааж идэх печень,  
гэтэл бүгдэд нь нэг нэгийг өгөөд  
өөрсдөө тороо үүрээд амтархан идээд  
сууж байнаа**



# Санхүүгийн тайлан

## ХҮҮХЭД ХӨГЖЛИЙН ХӨТӨЛБӨРИЙН ЗАРДАЛ

Цэцэрлэгийн хүүхдийн хоолны зардал  
Цэцэрлэгийн хангамжийн зардал  
Сургалт, судалгаа, хөгжүүлэлтийн хэрэглэгдэхүүний зардал

## ХҮҮХЭД ХАМГААЛЛЫН ХӨТӨЛБӨРИЙН ЗАРДАЛ

Хамгаалах байрны хүүхдийн хоолны зардал  
Хамгаалах байрны хүүхдийн хувцас зардал  
Хамгаалах байрны хүүхдийн ахуйн хэрэглэлийн зардал  
Сэтгэл заслын үйлчилгээний зардал  
Хүүхэд хамгааллын нийгэмшүүлэх үйлчилгээний зардал  
Хүүхэд хамгааллын үйлчилгээний эрүүл мэнд эм хангамж зардал  
Хүүхэд хамгааллын үйлчилгээний хангамж зардал/ үс замах анги цэвэр  
Бичиг хэргийн зардал  
Томилолтын зардал  
Тусгай арга хэмжээ, баяр ёслол, шагналын зардал  
Мэргэжилтнүүдийн цалингийн зардал

## АШИГЛАЛТЫН ЗАРДАЛ

Цөхилгаан  
Бохир ус  
Цэвэр ус  
Хог тээвэр  
Интернет  
Утас ид шидийн орон  
Утас хамгаалах байр

## ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДАЛ

Ажилчдын хоолны зардал  
Маркетингийн зардал  
Ногоон байгууламжийн арчилгааны зардал  
Цэвэрлэгээ, ариутгалын зардал  
Барилгын засварын зардал  
Тоног төхөөрөмжийн засварын зардал  
Шатахууны зардал  
Тээврийн зардал  
Шатахууны зардал ид шидийг орон нэг  
Тээврийн зардал ид шидийн орон нэг  
Томилолтын зардал ид шидийн орон нэг  
Бичиг хэргийн зардал ид шидийн орон нэг  
Сургалтын зардал  
Unifonn, үнэмлэх гм  
Татварын зардал Үл хөдлөх, газар  
Даатгалын зардал  
Ажилчдын цалингийн зардал

## НЭГДСЭН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДАЛ

Тусгай арга хэмжээ, баяр ёслол, шагналын зардал  
Бусад зардал \нотариат, орчуулга, карго\



# 43%

Хүүхэд хөгжлийн  
хөтөлбөрийн зардал  
**11,421,507 ₮**



# 38%

Хүүхэд хамгааллын  
хөтөлбөрийн зардал  
**10,113,985 ₮**

# 17%

Үйл ажиллагааны  
зардал  
**4,424,320 ₮**



# 1.1%

Ашиглалтын  
зардал  
**289,990 ₮**



# 1%

Нэгдсэн үйл  
ажиллагааны зардал  
**289,990 ₮**